

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дүгээр
сарын-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулаан шарын гол” ТӨХК-ийн 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01/299 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт байгууллагын батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Дулаан шарын гол” ТӨХК (П.Баярцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Тариф батлах тухай” 133 дугаар тогтоолын хавсралтын 1,2,5 дугаар мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 3-8 дугаар мөрөнд заасан Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2024 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	4,248.0	
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	33,704.0	
		Тогтмол	1,848.0	
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	3,052.0	
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	21,182.0	
		Тогтмол	1,162.0	
5	Төсөв, ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	15,435.0	
		Төг/Гкал	19,345.0	
6	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, "00"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,400.0	
7	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	3,900.0	
		Төг/хүн	5,200.0	
8	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар	3,000.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар	5,000.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх	Төг/сар	10,000.0